

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2020-2024 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ

/2020-2023 оны байдлаар/

2023.12.28

Дархан

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго, үндэслэл, арга зүй

Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ хийж, хүрсэн түвшинг тусгагдсан зорилт, арга хэмжээний зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлттэй харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж гаргах, удирдлагыг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, зорилт, арга хэмжээг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор гүйцэтгэлээ.

Зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

Хяналт-шинжилгээ, үнэлгээг Засгийн газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим санд буюу unelgee.gov.mn –ийн “Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр” цэсэнд байршсан 16 зорилтын 18 арга хэмжээ, Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн нэгтгэсэн тайлан, “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын 5 дугаар бүлгийн 5.1.2-т заасны дагуу хяналт-шинжилгээ, үнэлгээнд хамаарах мэдээллийг Засгийн газрын гишүүнтэй 2023 онд байгуулсан гэрээний үүргийн хэрэгжилтийн тайлан, статистик үзүүлэлт, аймгийн Орон нутгийн өмчийн газар, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын холбогдох албан тушаалтнуудаас тодруулсны үндсэн дээр иирүүлсэн нэмэлт мэдээлэл, ярилцлагад үндэслэн гүйцэтгэв.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

2020-2023 оны байдлаар Дархан-Уул аймгийн Засаг дарга хяналтанд авч, хэрэгжүүлэхийг үүрэг болгосон:

Эдийн засгийн бодлогын 5 зорилтын 5 арга хэмжээ,

Засаглалын бодлогын 2 зорилтын 4 арга хэмжээ,

Ногоон хөгжлийн бодлогын 3 зорилтын 3 арга хэмжээ,

Орон нутгийн хөгжлийн бодлогын 6 зорилтын 6 арга хэмжээ,

нийт **16 зорилтын 18 арга хэмжээг** хяналтанд авч, хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээг хийхэд 95.56% буюу 4.77 оноогоор үнэлэгдлээ.

Гурав. Дүгнэлт

Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний **2020-2023 оны** хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхэд **95.56%** буюу **4.77** онооны үнэлгээгээр үнэлэгдлээ.

Аймгийн ЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс боловсруулан бодлогын хэлтсүүдэд хүргүүлсэн “Зөвлөмж”-ийг хэрэгжүүлэн ажиллан, тайланг хугацаанд нь тайлагнаж, эргэх холбоотой ажилласан байна. Нэмэлт мэдээ, мэдээлэл, бодит тоон үзүүлэлтийг шуурхай ирүүлж, тайлбарыг ирүүлж ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2023.07.06-ны өдрийн 01/561 тоот албан бичгээр ирүүлсэн “Тайлан, зөвлөмж хүргүүлэх тухай” –ийн хүрээнд эрчимжүүлэх шаардлагатай 4 арга хэмжээний хэрэгжилтийг хангуулахад анхаарч удирдлагын болон зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан нь сайшаалтай байна.

Үнэлгээг 16 зорилтоор харуулбал:

| № | Хэрэгжилт | Бүгд | Бодлогоор, үүнээс | | | | |
|---------------------------------------|-------------------|--|-----------------------------|---------------------------|------------------------------|-----------------------------------|---|
| | | | III. Эдийн засгийн бодлого | IV. Засаглалын бодлого | V. Ногоон хөгжлийн бодлого | VI. Орон нутгийн хөгжлийн бодлого | |
| 1. | Нийт зорилтын тоо | 16 | 5 | 2 | 3 | 6 | |
| 2. | Үүнээс | Үр дүнтэй буюу 100.0% | 10 | 3 | 2 | 1 | 4 |
| | | Тодорхой үр дүнд хүрсэн буюу 70-99.0% | 6 | 2 | - | 2 | 2 |
| | | Эрчимжүүлэх шаардлагатай буюу 31-69.0% | - | - | - | - | - |
| | | Үр дүнгүй буюу 0-30.0% | - | - | - | - | - |
| Хэрэгжилтийн дундаж хувь, оноо | | 96.56% буюу 4.77 | 92.0% буюу 4.60 оноо | 100% буюу 5.0 оноо | 93.33% буюу 4.66 оноо | 96.66% буюу 4.83 оноо | |

Үнэлгээг 18 арга хэмжээгээр харуулбал:

| № | Хэрэгжилт | Бүгд | Бодлогоор, үүнээс | | | | |
|---------------------------------------|--------------------|------------------------------|-----------------------------|---------------------------|------------------------------|-----------------------------------|---|
| | | | III. Эдийн засгийн бодлого | IV. Засаглалын бодлого | V. Ногоон хөгжлийн бодлого | VI. Орон нутгийн хөгжлийн бодлого | |
| 1. | Зорилтын тоо | 16 | 5 | 2 | 3 | 6 | |
| 2. | Арга хэмжээний тоо | 18 | 5 | 4 | 3 | 6 | |
| 3. | Үүнээс | 100.0% | 12 | 3 | 4 | 1 | 4 |
| | | 90.0% | 5 | 1 | - | 2 | 2 |
| | | 70.0% | 1 | 1 | - | - | - |
| | | 50.0% | - | - | - | - | - |
| | | 30.0% | - | - | - | - | - |
| | | 0.0% | - | - | - | - | - |
| Хэрэгжилтийн дундаж хувь, оноо | | 95.56% буюу 4.77 оноо | 92.0% буюу 4.60 оноо | 100% буюу 5.0 оноо | 93.33% буюу 4.66 оноо | 96.66% буюу 4.83 оноо | |

Холбогдох зохицуулах салбарын зорилт, арга хэмжээгээр харуулбал:

- ✓ Эдийн засгийн бодлогын 5 зорилтын 5 арга хэмжээний хэрэгжилт 92.0%,
- ✓ Засаглалын бодлогын 2 зорилтын 4 арга хэмжээний хэрэгжилт 100.0%,
- ✓ Ногоон хөгжлийн бодлогын 3 зорилтын 3 арга хэмжээний хэрэгжилт 93.33%,
- ✓ Орон нутгийн хөгжлийн бодлогын 6 зорилтын 6 арга хэмжээний хэрэгжилт 96.66%-ийн үнэлгээтэй байна.

Дөрөв. Цаашид хэрэгжүүлэх зөвлөмж

Сайн тал: 2023 оны эхний хагас жилийн хэрэгжилтэд өгсөн Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, тайланг хугацаанд нь тайлагнаж, эргэх холбоотой ажиллалаа. Нэмэлт мэдээ, мэдээлэл, бодит тоон үзүүлэлтийг шуурхай ирүүлж, тайлбарыг өгч ажиллалаа.

Монгол Улсын Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газрын даргын 2023.07.06-ны өдрийн 01/561 тоот албан бичгээр ирүүлсэн “Тайлан, зөвлөмж хүргүүлэх тухай” –ийн хүрээнд эрчимжүүлэх шаардлагатай 4 арга хэмжээний хэрэгжилтийг хангуулахад анхаарч удирдлагын болон зохион байгуулалтын арга хэмжээг авч ажилласан нь сайшаалтай байна.

2024 онд 70, 90%-ийн хэрэгжилттэй арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлэхэд салбар хоорондын хамтын ажиллагаатай ажиллахыг зөвлөж байна.

ТАНИЛЦСАН:
ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГА Б.АЗЖАРГАЛ

ХЯНАСАН:
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН
ДАРГА П.БАЯРСАЙХАН

ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ ХИЙСЭН:
АХЛАХ МЭРГЭЖИЛТЭН О.МӨНХСҮРЭН